

“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 сарын 04 өдөр

Улаанбаатар хот

Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 01 сарын 04-ний өдрийн 10:00 цагт БиДиСЕК ҮЦК ХК-ийн төв байрны 201 тоотод эхлэв.

Хурлын дэгийн дагуу 10:10 хүртэл ирц бүртгэсэн.

Үүний дараагаар Тооллогын комисс хурлын ирцийн тогтоолыг танилцуулав. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд нийт саналын эрхтэй хувьцааны 82.04% буюу 32,723 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар болон биечлэн оролцож хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн.

Тооллогын комиссын тогтоол

Компанийн тухай хуулийн 67.3.1, 69.1, 69.2 болон Хот Девелопмент ХК-ийн компанийн дүрмийн 3.14, Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 32,723 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 39,885 ширхэг хувьцааны 82.04% болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 3.14 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 82.04%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга: Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнээр өнөөдөр хуралдах боломжтой болсон байна. Хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя.

1. Өрийг хувьцаагаар солих төслийг танилцуулах, батлах
2. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай хэлэлцэх
Хувьцаа эзэмшигчдийн санал, асуулт, хариулт
3. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах
Хувьцаа эзэмшигчдийн санал, асуулт, хариулт
4. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай;
Хувьцаа эзэмшигчдийн санал, асуулт, хариулт
5. Санал хураалт
6. Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
7. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
8. Хурлын дарга хурлыг хаах гэсэн дараалалтай явна.

1. Өрийг хувьцаагаар солих төслийг танилцуулах

Өрийг хувьцаагаар солих төслийг гүйцэтгэх захирал Н.Батгэрэл танилцуулав.

Гүйцэтгэх захирал: Хот Девелопмент ХК нь 1991 онд байгуулагдсан өмч хувьчлалаар Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэн үйл ажиллагаа явуулдаггүй, хөрөнгөгүй компани буюу хөрөнгийн зах зээл дээр нэрлэдгээр shell компани юм.

2013 онд АНУ-ын хөрөнгө оруулалтын сан Firebird Хот Девелопмент ХК-ийн хяналтын багцыг худалдан авч хөрөнгө оруулалт, санхүүжилт хийн ажиллаж байсан ч тухайн үеийн эдийн засаг, хөрөнгө оруулалтын нөхцөл байдлаас шалтгаалан төсөл амжилтгүй болсон байдаг.

Хот Девеломент ХК нь дээрх ажиллагаанаас шалтгаалан үүссэн одоогийн баланс дээр буй өр төлбөрийг төлж барагдуулах санхүүгийн чадамжгүй болсон тул компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэн Зээлдүүлэгчид эзэмшүүлэхээр төлөвлөж байна.

Компани одоогийн тайлан баланс дээр буй зээлийг хувьцаа руу хөрвүүлснээр өөрийн хөрөнгийн зохистой харьцааг бий болгох, өрийг бууруулах, балансыг цэгцлэх ач холбогдолтой. Энэхүү ажиллагааг гүйцэтгэсний дараа хөрөнгө оруулагчид, компаниуд Хот Девелопмент ХК-ийг сонирхон хөрөнгө оруулалт хийснээр компанийн үйл ажиллагаа сайжрах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдах, хувьцааны үнэ цэнэ өсөх, хөрөнгийн бирж дээр идэвхтэй арилжигддаг компани бий болох боломжтой.

Энэхүү зээл, өр төлбөр хэрхэн үүссэн тухайд дээр дурдсанчлан 2013 онд Hot Holdings S.A.R.L компаниас 250,000 (хоёр зуун тавин мянга) ам.долларын үндсэн төлбөр, жилийн 10%-ийн хүүтэй, 2 жилийн хугацаатай санхүүжилтыг хөрөнгө оруулагчийн хүсэлтээр хөрвүүлэх нөхцөлтэйгээр 2013 оны 06 сарын 11-ны өдрийн 01 дугаартай “Хөрвөх зээлийн гэрээ”-г байгуулсан. Энэхүү гэрээний дагуу 200,000 ам долларын хөрөнгө оруулалт Hot Holdings S.A.R.L-аас орж ирсэн.

Та бүхэн хөрвөх зээлийн гэрээний хуулбар болон бусад зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг өрийг хувьцаагаар солих төслөөс авах боломжтой.

Зээлийн зарцуулалтын тухайд компани нь 150,000 ам долларыг зам ашиглалт, засварын ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулах, түүнтэй холбоотой тусгай зөвшөөрлийг авахаар, 50,000 ам.долларыг үйл ажиллагааны зардалд зарцуулсан.

№	Зарцуулалт	Дүн /USD/
1	Хөрөнгө оруулалт	150,000
2	Үйл ажиллагааны зардал	50,000
	Нийт дүн	200,000

Хэдийгээр 2013-2016 онд эдийн засгийн өсөлт удааширсан, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт буурсан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан дээрх ажиллагаа амжилтгүй болж өмнөх хөрөнгө оруулагчид нь хувьцаа болон зээлийг одоогийн Зээлдүүлэгчид шилжүүлэн төслөөс гарсан.

Хувьцаа эзэмшигч Б.Лхагвадорж нь 2019 оны 04 сарын 15-ны өдрийн “Зээл шилжүүлэх гэрээ”-гээр төлөгдөөгүй үлдсэн 189,000 (зуун наян есөн мянга) ам долларын үндсэн төлбөр болон холбогдох хүүгийн төлбөрийг шилжүүлэн авсан.

Компани нь 2019 оны 01 сарын 29-нд 11,000 долларын эргэн төлөлт, 2019 оны 05 сарын 08-нд 4,000 долларын эргэн төлөлтийг хийснээр зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл 185,000 доллар болсон.

Хүүгийн төлбөр нь 2013 оны 06 сарын 11-ны өдрөөс эхлэн 2019 оны 01 сарын 01-ны өдрийн хооронд тооцогдон нийт 110,849.4 ам.доллар байна.

Компанийн санхүүгийн тайланд өр төлбөрийг ам.доллараар тусгасан байгаа ба НББОУС-ын стандартын 21-т заасны дагуу өдөр бүр төгрөгөөр илэрхийлэх шаардлагатай байдаг. Компанийн үнэлгээ гарсан, нэгж хувьцааны үнэ тогтоосон өдрийн буюу 2020 оны 12 сарын 29-ны өдрийн хаалтын ханшаар ханшийн тэгшитгэл хийхэд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр дараах байдалтай байна.

№	Төлбөр	доллараар	төгрөгөөр
1	Үндсэн төлбөр	185,000.00	527,153,800.00
2	Хүүгийн төлбөр	110,849.40	315,863,148.31
3	Нийт	299,849.40	843,016,948.31

Зээлийн үлдэгдэл дээрх байдалтай байгаа бөгөөд Зээлдүүлэгч Б.Лхагвадорж нь уг зээлийг энгийн хувьцаа хөрвүүлэх мэдэгдлээ компанид 2020 оны 12 сарын 30-ны өдөр ирүүлсэн байна.

2. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай;

Хурлын дарга: Өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хувьцааны хөрвөх үнэ, тоо ширхэг болон бусад нөхцлийг тодорхойлох шаардлагатай.

Компанийн тухай хуулийн 55.7, 55.8 дугаар зүйлд хувьцаат компанийн хувьд хувьцаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллага, аудитын байгууллагын дүгнэлт, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзана гэж заасан байдаг.

Компанийн дүрмийн 2.1-д заасны дагуу хувьцааны нэрлэсэн үнэ нь 100 төгрөг бөгөөд Компанийн тухай хуулийн 32.5-д Хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр гаргахыг хориглосон байдаг.

Компани нь хараат бус үнэлгээний байгууллага Ашид билгүүн ХХК 2020 оны 12 сарын 07-ны өдөр байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан ажиллаж байна. Үнэлгээний компани нь 2020 оны 12 сарын 29-ны өдөр Үнэлгээний тайланг гарган ирүүлсэн байна. Хараат бус үнэлгээний байгууллага дараах байдлаар дүгнэжээ.

- Компани сүүлийн 3-аас дээш жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлж орлого олоогүй, компаний үйл ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөө тодорхойгүй байх тул урьдчилан харах боломжтой ирээдүйг түүхэн мэдээлэлд үндэслэн таамаглах боломжгүй байна.
- Санхүүгийн тайланд тусгагдсан өр төлбөрийг цаашид төлж барагдуулах санхүүгийн чадамж тодорхойгүй тул Монгол улсын “Компаний тухай” хуулийн 32.5 дугаар зүйлийг даган мөрдөж 2020 оны хагас жилийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт өр төлбөрийн дүнг хувьцааны нэрлэсэн үнэд харьцуулж өрийг энгийн энгийн хувьцаагаар солих тоо хэмжээг тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ.
- “Хот девелопмент” ХК-ий өрийг хувьцаагаар солих үйл ажиллагаанд зах зээлд арилжаалах боломжтой энгийн хувьцааны тоо 8,367,516 ширхэг байх боломжтой байна.

- ҮОУС-104-180. Аж ахуйн нэгжийн тусгай хүчин зүйлсэд хамаарах хөрөнгийг ашиглах талаар тухайн аж ахуйн нэгжид цор ганц хамаарах боломжит нөхцөл гэсэн тусгай төсөөллийн дагуу үнэлсэн тул энэ тайлангийн үнэлгээний дүнг зөвхөн "Хот девелопмент" ХК өрийг хувьцаагаар солих үйл ажиллагаанд ашиглана.

МХБ-ийн 2020 оны 12 сарын 28-ны өдрийн 01/879 тоот албан бичигт дурдснаар Хот Девелопмент ХК-ийн сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш 57 төгрөг байна.

Компанийн өөрийн хөрөнгө сөрөг дүнтэй буюу дансны үнэ сөрөг буюу -20,979 гарч байна.

Компанийн тухай хууль, Үнэлгээний компанийн зөвлөмж болон бусад холбогдох нөхцлийг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 20/07 тоот тогтоолоор нэмж гаргах хувьцааны үнийг 100 төгрөгөөр тогтоосон байна.

Хөрвөх тооцоолол

Компани 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 8,430,169 ширхэг энгийн хувьцааг нэгжийг нь 100 төгрөгөөр үнэлэн нэмж гаргахад дараах тооны хувьцааг гаргахаар байна.

Төлбөр	Доллараар	Төгрөгөөр
Хөрвөх зээлийн гэрээний нийт үндсэн төлбөр USD	185,000.00	527,153,800.00
Хүүгийн төлбөр USD	110,849.40	315,863,148.31
Хувьцаагаар солих өрийн нийт дүн MNT	295,849.40	843,016,948.31
Хувьцааны үнэ MNT		100
Хөрвөх хувьцааны тоо ширхэг		8,430,169.48
Хөрвөх хувьцааны тоо ширхэг бүхэлчилсэн		8,430,169.00
Хөрвөх хувьцааны дүн бүхэлчилсэн	295,849.38	843,016,900.00
Бутархай үлдэгдэл		48.31

Компанийн дүрэмд орох өөрчлөлт

Компани нь нэмж хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан компанийн гаргасан хувьцаа болон хувь нийлүүлсэн хөрөнгөд дараах өөрчлөлт орно.

Өмнөх заалт	Шинэчилсэн заалт
2.1.Компани нь нэг бүр нь нэг зуун (100.00) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 39,885 ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,988,500 төгрөг болно.	2.1.Компани нь нэг бүр нь нэг зуун (100.00) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 8,470,054 ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь 847,005,400 төгрөг болно.

Компанийн хувьцаа эзэмшилд орох өөрчлөлт

Хувьцаа эзэмшигч	Одоо		Өрийг хувьцаагаар сольсны дараа	
	Хувь	Тоо ширхэг	Хувь	Тоо ширхэг
"БиДиСЕК ҮЦК" ХК	40.34%	15,188	0.18%	15,188
"БиДиСи Эй Пи" ХХК	32.84%	13,100	0.15%	13,100
Б.Лхагвадорж	8.84%	3,525	99.57%	8,433,694.00
5 хүртэлх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид	17.98%	8,072	0.10%	8,072
Нийт	100%	39,885	100%	8,470,054

Хувьцаа эзэмшигч Х.Батхишиг: Хууль журмын дагуу тогтоох нь зүйтэй. Нөгөө талаас энэ компани маань үйл ажиллагаа явуулдаггүй, алдагдалтай компани тул хувьцаанд өндөр үнэ тогтоох нь зохисгүй тул 100 төгрөгөөр тогтоох саналыг дэмжиж байна. Мөн энэхүү өрийг

хувьцаагаар солих төсөлтэй танилцсан, компанийн цаашдын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ гэж найдаж байгаа тул өрийг хувьцаагаар солихыг дэмжиж байна.

3. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах тухай;

Хурлын дарга: Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйл, 89 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү хэлцэл нь сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл болж байгаа тул сонирхлын зөрчилгүй буюу дээрх асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн шийдвэрээр энэхүү хэлцлийг батална.

Зээлдүүлэгч Б.Лхагвадорж нь компанийн 3,525 ширхэг хувьцаа буюу 8.83 хувийг эзэмшдэг ба түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болох дараах хувьцаа эзэмшигчид энэхүү өрийг хувьцаагаар солих асуудлаар сонирхлын зөрчилтэй болж буй тул өрийг хувьцаагаар солих асуудлаар саналын эрхгүй энэ хуралд оролцож байгаа.

№	Хувьцаа эзэмшигч	Хувь	Тоо, ширхэг
1	"БиДиСЕК ҮЦК" ХК	40.34%	15,188
2	"БиДиСи Эй Пи" ХХК	32.84%	13,100
3	Б.Лхагвадорж	8.84%	3,525
	Нийт	82.02%	31,813

Их хэмжээний хэлцэл болох тухайд Компанийн тухай хуулийн 87.1.1 болон 87.1.2-т заасны дагуу 25%-иас дээш хэмжээний энгийн хувьцаа буюу 8,430,169 ширхэг хувьцаа нэмж гаргаж буй тул их хэмжээний хэлцэл болж байна.

Хувьцаа эзэмшигч Х.Батхишиг: Хэлцэл хийхийг зөвшөөрч байна. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл болж буй тул шаардах эрх үүсэх үү. Энэхүү ажиллагааг хэрхэн зохион байгуулахаар төлөвлөж байгаа вэ?

Хурлын дарга: Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.1.2 -д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй байна.

Уг эрхтэй холбогдуулан "Хот Девелопмент" ХК нь Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

Энэхүү хурлын шийдвэр гарсан тохиолдолд ТУЗ нь шаардах эрх хэрэгжүүлэх журмыг баталж, үнэ тогтоон шаардах эрх хэрэгжүүлэх ажиллагааг дүрэм журмын дагуу зохион байгуулна.

Нэг анхаарах зүйл нь Хот Девелопмент ХК нь хувьцаат компани тул Санхүүгийн Зохицуулах Хорооноос өрийг хувьцаагаар солих, хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн тухай шийдвэр гарсны дараа шаардах эрхийн журмын дагуу хувьцааны төлбөрийг шилжүүлнэ.

4. Компанийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай;

Хурлын дарга: Компанийн тухай хуулийн 38.8, 62.1.8 болон Компанийн дүрмийн 2.4-д заасны дагуу одоогийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай шийдвэрлэнэ.

Хувьцаа эзэмшигч Х.Батхишиг: Энэхүү өрийг хувьцаагаар солих төсөл хэрэгжин компани цаашдаа үйл ажиллагаагаа сэргээн үр ашигтай ажиллаж, жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцаа үнэ цэнэтэй болоосой гэж хүсч байгаа тул энэ удаад тэргүүн ээлжийг энэ удаад хэрэгжүүлэхгүй байх саналтай байна.

Хурлын дарга: Саналын хуудсаар санал ирүүлсэн хувьцаа эзэмшигч маань мөн тэргүүн ээлжийг хэрэгжүүлэхгүй байхаар санал ирүүлсэн байгаа. Саналын хуудас дээр тэргүүн ээлжийг хэрэгжүүлэхгүй байхаар тусгасан байгаа тул та бүхэн зөвшөөрсөн гэдгийг сонгож саналаа өгөхийг анхаараарай.

Хувьцаа эзэмшигчдээс өөр асуулт, санал ирээгүй тул санал авах, тоолох тооллогын комиссын тогтоолыг танилцуулах, хурлаар гарах шийдвэрийг танилцуулах, хурал хаах гэсэн ажил үлдлээ.

5. Санал хураалт

Хурлын дарга: За тэгэхээр энэхүү асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналыг хуудсыг бөглөн тооллогын комиссын гишүүдэд өгнө үү. Саналын хуудас бөглөх заавар, анхаарах зүйлийг уншиж танилцуулья.

- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Ердийн аргаар өгөх санал хураалтад хэлэлцэх асуудал тус бүр дээр нэгээс олон тэмдэглэгээ хийсэн тохиолдолд санал хүчингүйд тооцогдоно.
- Гарын үсгээ зураагүй санал хүчингүйд тооцогдоно.
- Итгэмжлэлээр санал өгч буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэл дээрх өөрийн баталгаат гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
- Насанд хүрээгүй хувьцаа эзэмшигчийн асран хамгаалагч нь хүүхдийнхээ бус өөрийнхөө гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
- Гарын үсэггүй санал хүчингүйд тооцогдоно.

6. Тооллогын комиссын дүн:

Тооллогын комисс тооллогын дүнг танилцуулав.

1. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солих төслийг батлах асуудлаар саналын эрхтэй, хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 910 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
910	100.00%	0	0.00%	0	0.00%

2. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргах тухай асуудлаар саналын эрхтэй, хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 910 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
910	100.00%	0	0.00%	0	0.00%

- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихтой холбоотой сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах асуудлаар саналын эрхтэй, хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 910 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
910	100.00%	0	0.00%	0	0.00%

- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан хаалттай нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай асуудлаар саналын эрхтэй, хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 910 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
910	100.00%	0	0.00%	0	0.00%

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал амжилттай явагдаж, өрийг хувьцаагаар солих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ. Тогтоолыг уншиж танилцуулья.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.3 дахь заалт, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, 38 дугаар зүйлийн 38.8 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт болон Хот Девелопмент ХК-ийн 2021 оны 01 сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

- Хот Девелопмент ХК болон Hot holdings S.A.R.L хооронд 2013 оны 06 сарын 11-ний өдрийн 01 дугаартай “Хөрвөх зээлийн гэрээ”, Зээлдүүлэгч Б.Лхагвадорж болон Hot holdings S.A.R.L хооронд 2019 оны 04 сарын 15-ны өдрийн “Зээл шилжүүлэх гэрээ”-ний дагуу 843,016,900 төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Хот Девелопмент ХК-ийн 8,430,169 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэхийг зөвшөөрсүгэй.
- Өрийг хувьцаагаар солих төслийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихтой холбогдуулан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
- Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсөнтэй холбогдуулан Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 843,016,900 төгрөгөөр нэмэгдүүлж, Хот Девелопмент ХК-иас дараах төрөл, үнэ, тоо ширхэг бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гарган Зээлдүүлэгч Б.Лхагвадоржид эзэмшүүлсүгэй. Нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан Хот Девелопмент ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

1) Хувьцааны төрөл

Энгийн

- | | |
|---------------------------|------------------|
| 2) Тоо ширхэг | 8,430,169 ширхэг |
| 3) Нэгж хувьцааны үнэ | 100 төгрөг |
| 4) Хувьцааны нэрлэсэн үнэ | 100 төгрөг |
5. Өрийг хувьцаагаар сольж буйтай холбоотойгоор Хот Девелопмент ХК-иас хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг Хот Девелопмент ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
 6. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солих төсөл, журмыг хэрэгжүүлж ажиллах, өрийг хувьцаагаар солих болон их хэмжээний, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэнтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх журмыг батлах, хувьцаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үүссэн асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах бүрэн эрхийг Төлөөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
 7. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар сольж буйтай холбоотойгоор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Н.Батгэрэл)-д даалгасугай.
 8. Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар сольж, хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөн, нэмэлт хувьцаа бүртгэгдсэний дараа компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Н.Батгэрэл)-д даалгасугай.

8. Хурлыг хаах

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон, санал, зөвлөмжөө өгсөн, саналын хуудсаар оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ талархсанаа илэрхийлье. Өрийг хувьцаагаар солих төсөл амжилттай хэрэгжиж, Хот Девелопмент ХК-ийн үйл ажиллагаа сэргэн, өргөжсөнөөр Монголын хөрөнгийн биржид идэвхтэй арилжигддаг компани болж хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэ цэнэ нэмэгдэнэ гэж найдья.

Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хаасныг мэдэгдье.

Тэмдэглэл хөтөлсөн:

Тэмдэглэл хянасан хурлын дарга:



/Х.Азбаяр/

/Д.Даянбилгүүн/